



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАНДАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2018.10.26 № 05/8842.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Татварын ерөнхий газрын харьяа Булган аймгийн татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Дашгайн Лхагвасүрэн, Өмнөговь аймгийн татварын хэлтсийн Эрсдэл, статистикийн тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Сольхүүгийн Өлзийбат нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэ тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин нэр дэвшигч Д.Лхагвасүрэн нь санхүү татвар, даатгалын чиглэлээр түр сургалт явуулах, аудитын үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Мандах мотиваци аудит" ХХК-ийн үүсгэн байгуулагч, 20 хувийг эзэмшиж байгаа тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт, хориглолтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ ДАРГА,  
АХЛАХ КОМИССАР Л.СҮХ-ОЧИР



0014918